

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН

**“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ,
ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ,
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ”**

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/12-ШТА-НА

БУЛГАН АЙМАГ

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 7034-2716 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

Агуулга	
Товчилсон үгийн тайлбар.....	3
хүснэгтийн товъёг	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
НЭГ. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН 50 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСАА БҮРТГҮҮЛЭЭГҮЙ, 58 НЭР ДЭВШИГЧ ЗАРДЛЫН ТАЙЛАН ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....	5
1.1 Сонгуулийн зардлын дансаа хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 50 нэр дэвшигч байна.....	5
1.2 Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 734, тайлангаа ирүүлээгүй 58 нэр дэвшигч байна.	6
ХОЁР. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН 12.8 САЯ ТӨГРӨГИЙГ УЛСЫН ОРЛОГО БОЛОН ХАНДИВЛАГЧИЙН ДАНСАНД БУЦААН ШИЛЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.....	7
2.1 Сонгуульд оролцогчдод нийт 204.6 сая төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн бол нийт нэр дэвшигчдийн 38.6 хувь нь огт хөрөнгө байршуулаагүй, сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэгэн зардал гаргаагүй гэж тайлагнасан байна.	7
2.2 Нэр дэвшигч сонгуулийн үйл ажиллагаанд нийт 202.4 сая төгрөгийг зарцуулсан байна.....	8
Дүгнэлт.....	9

Товчилсон үгийн тайлбар

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАН	Монгол Ардын нам
АН	Ардчилсан нам
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
САИН	Сайн ардчилсан иргэдийн нэгдсэн нам
ИХН	Иргэний хөдөлгөөний нам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Нэр дэвшигчдийн тоо	4
Хүснэгт 2	Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын данс бүртгүүлсэн байдал	5
Хүснэгт 3	Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайлан ирүүлсэн байдал	6
Хүснэгт 4	Сонгуулийн зардлын ангилал	8

1. Аудитын нэр, код: Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын санхүүжилт, түүний гүйцэтгэлд аудит хийж дүгнэлт гарган нийтэд мэдээлэх, ГНАГ-2024/12-ШТА-НА.

2. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заасныг үндэслэн Булган аймаг дахь Төрийн аудитын газар нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хяналаа.

3. Аудитын зорилго: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие даан нэр дэвшигчдийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандив, сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

4. Аудитын хамрах хүрээ: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслээс болон бие дааж нэр дэвшигчдийн хувийн аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан аудитын дүгнэлт, аудитын дэлгэрэнгүй тайлан, аудит хийгдсэн сонгуулийн зардлын тайлангийн маягтууд, харилцагч банкны дансны хуулга бусад шаардлагатай баримтуудыг хамрууллаа.

5. Арга зүй: Аудитын ажлыг гүйцэтгэхэд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан “Сонгуулийн зардлыг тайлагнах заавар, аргачлал”-ыг үндэслэн нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө, нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвсэл, зарим нэр дэвшигчдээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

6. Үндсэн мэдээлэл: Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд аймгийн ИТХ-д 21 тойрогт намаас болон бие даагч нийт 74 нэр дэвшигч, сумын ИТХ-д 718 нэр дэвшигч оролцсон байна.

Хүснэгт № 1 Нэр дэвшигчдийн тоо

№	Нам, эвслийн нэр	Аймгийн ИТХ-д нэр дэвшигчийн тоо	Сумын ИТХ-д нэр дэвшигчийн тоо
1	Монгол Ардын нам	29	313
2	Ардчилсан нам	29	326
3	ХҮН нам	10	
4	Иргэний хөдөлгөөний нам	4	66

5	Сайн ардчилал иргэний нэгдсэн нам	2	
6	Бие даагч		13
	ДҮН	74	718

Аймгийн ИТХ-д 5 нам, эвслийн 74 нэр дэвшигч, сумын ИТХ-ын сонгуульд 3 намын 705, бие даагч 13 хүн нэр дэвшин сонгуульд оролцсон байна.

НЭГ. АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН 50 НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСАА БҮРТГҮҮЛЭЭГҮЙ, 58 НЭР ДЭВШИГЧ ЗАРДЛЫН ТАЙЛАН ИРҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

1.1 Сонгуулийн зардлын дансаа хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 50 нэр дэвшигч байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлсэн 742 нэр дэвшигч, бүртгүүлээгүй 50 нэр дэвшигч байна.

Хүснэгт № 2 Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын данс бүртгүүлсэн байдал

№	Нам, эвсэл, бие даагчийн нэр дэвшигч	Аймгийн ИТХ-д нэр дэвшигчийн тоо		Сумын ИТХ-д нэр дэвшигчийн тоо		Тайлбар
		Данс бүртгүүлсэн	Данс бүртгүүлээгүй	Данс бүртгүүлсэн	Данс бүртгүүлээгүй	
1	Монгол Ардын нам	29		310	3	
2	Ардчилсан нам	29		296	30	
3	ХҮН нам	6	4			
4	Иргэний хөдөлгөөний нам	4		55	11	
5	Сайн ардчилал иргэний нэгдсэн нам	2				
6	Бие даагч			11	2	
	Дүн	70	4	672	46	

Аймаг, сумын ИТХ-д 50 нэр дэвшигч сонгуулийн үйл ажиллагаанд ашиглах дансаа бүртгүүлээгүй нь Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4, 50 дугаар зүйлийн 50.1, 50.2, 50.3-р зүйлийг зөрчсөн байна.

1.2 Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 734, тайлангаа ирүүлээгүй 58 нэр дэвшигч байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45

хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 734, тайлангаа ирүүлээгүй 58 нэр дэвшигч байна.

Хүснэгт № 3 Нам, эвсэл, нэр дэвшигчдийн зардлын тайлан ирүүлсэн байдал

№	Нам, эвсэл, бие даагчийн нэр дэвшигч	Аймгийн ИТХ-д нэр дэвшигч		Сумын ИТХ-д нэр дэвшигч	
		Зардлын тайлаан ирүүлсэн	Зардлын тайлан ирүүлээгүй	Зардлын тайлаан ирүүлсэн	Зардлын тайлан ирүүлээгүй
1	Монгол Ардын нам	28	1	310	3
2	Ардчилсан нам	29		276	50
3	ХҮН нам	9	1		
4	Иргэний хөдөлгөөний нам	3	1	64	2
5	Сайн ардчилал иргэний нэгдсэн нам	2			
6	Бие даагч			13	
	Дүн	71	3	663	55

Сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлсэн 734 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа бүгд аудитын хуулийн этгээдээр баталгаажуулсан байна.

Орон нутгийн сонгуульд 5 нам оролцсон бөгөөд зардлын тайлангаа аймгийн МАН, аймгийн АН ирүүлсэн бол ХҮН, САИН, ИХН-ууд тайлангаа ирүүлээгүй байна.

Иймд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3-д “сонгуулийн санхүүжилт, түүний зарцуулалтад гарсан зөрчлийн талаар баримт бичиг үйлдэх, бүрдүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх,” Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.12¹, 6.22² хэсэгт заасны дагуу зардлын тайлан ирүүлээгүй 58, зардлын данс бүртгүүлээгүй 50 нэр дэвшигчдийн жагсаалтыг хуулийн дагуу шалган шийдвэрлүүлэхээр Булган аймгийн ЗДТГ-ын СТСХ-т 2025.01.10-ны өдрийн 03, Татварын хэлтэст 2025.01.10-ны өдрийн 04 тоот албан бичгээр тус тус хүргүүллээ.

ХОЁР. ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН 12.8 САЯ ТӨГРӨГИЙГ УЛСЫН ОРЛОГО БОЛОН ХАНДИВЛАГЧИЙН ДАНСАНД БУЦААН ШИЛЖҮҮЛЭЭГҮЙ БАЙНА.

¹ 6.12.татварын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.5 дугаар зүйл, 7.10, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 10.6 дугаар зүйл, 11.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 11.19, 11.24 дүгээр зүйл, 14.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.4 дүгээр зүйл, 17.1 дүгээр зүйлийн 21, 22, 24 дэх хэсэгт заасан зөрчил;

² 6.22.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 25, 27 дахь хэсэгт заасан зөрчил;


2.1 Сонгуульд оролцогчдод нийт 204.6 сая төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн бол нийт нэр дэвшигчдийн 38.6 хувь нь огт хөрөнгө байршуулаагүй, сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэгэн зардал гаргаагүй гэж тайлагнасан байна.

Сонгуулийн хороо Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс сонгуулийн зардлын тайлангаа ирүүлсэн 734 нэр дэвшигчдийн дансанд нийт 204.6 сая төгрөгийн орлого төвлөрч, сонгуулийн үйл ажиллагааны зардалд 202.4 сая төгрөг зарцуулж, харилцах дансанд 2.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна. Үүнд:

Нам, эвслээс 21 нэр дэвшигчид 6.0 сая төгрөг, өөрийн хөрөнгө оруулсан 196 нэр дэвшигч 46.6 сая төгрөгийн зарцуулсан байна.

Аймаг, сумын ИТХ-д нэр дэвшигчдэд 698 иргэн 148.1 сая төгрөг, 4 хуулийн этгээд 3.9 сая төгрөгийн мөнгөн хандив төвлөрсөн бол 46 иргэн 11.0 сая төгрөгийн мөнгөн бус хандив өгсөн байна.

График № 1 Мөнгөн болон мөнгөн бус хандив



Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57.1³ -т заасан олон нийтэд мэдээлэх хэмжээний хандивыг нэр дэвшигчид 25 иргэн 36.5 сая, 1 хуулийн этгээд 3.0 сая төгрөгийн мөнгөн хандив өгсөн бол намд 20 иргэн 40.0 сая төгрөгийг хандив өгсөн байна.

Нэр дэвшигчдийн 38.6 хувь буюу 306 нэр дэвшигчдийн зардлын дансаар гүйлгээ гаргаагүй байна.

Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл дутуу, буцах хаяг тодорхойгүй зэрэг шалтгаантай хуулиар зөвшөөрөөгүй 36.7 сая төгрөгийн хандив тайлагнаснаас 23.1 сая төгрөгийн хандивыг буцаасан, 0.7 сая төгрөгийг улсын орлого болгосон, 135

³ 57.1.Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ

иргэний 12.9 сая төгрөгийн хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаан шилжүүлээгүй байна.

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Монгол Ардын намын зардлын дансанд 21 иргэнээс 40.4 сая төгрөгийн орлого оруулж зарцуулсан, Ардчилсан намын зардлын дансаар гүйлгээ гараагүй аудитаар дүгнэлт гаргуулсан байна. Бусад намууд аудитын дүгнэлт ирүүлээгүй байна.

2.2 Нэр дэвшигч сонгуулийн үйл ажиллагаанд нийт 202.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардалд нийт 202.4 сая төгрөг зарцуулснаас сонгуулийн зардалд 176.7 сая, бусад зардалд 25.7 сая төгрөг зарцуулжээ. Үүнд:

Хүснэгт № 4 Сонгуулийн зардлын ангилал

№	ЗАРДЛЫН АНГИЛАЛ		Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Сонгуулийн сурталчилгааны	Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зардал	27.1
2	материал хэвлүүлэх, сонгогчдод тараах	Сонгуулийн сурталчилгааны материал тараах зардал	5.5
3	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал		2.2
4	Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		3.6
5	Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		21.3
6		Ухуулах байрны түрээсийн зардал	7.5
7	Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах, хөлс, урамшууллын зардал	45.2
8		Нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал	30.5
9		Нам, эвслээс зарцуулах томилолтын зардал	0.09
10		Сонгуулийн сурталчилгаанд ашиглах бусад зардал	26.5
11	Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах		3.7
12	Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийлүүлэх зардал		1.2
13	Цахим орчин ашиглах зардал	Нам, эвсэл, нэр дэвшигчийн өөрийн тус бүр нэг цахим хуудаст шаардагдах зардал	0.2
14		Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудаст шаардагдах зардал	2
15		Бусад цахим хуудсыг сурталчилгаанд ашиглах нам, эвсэл болон нэр дэвшигчийн зардал	0.09
16	Бусад зардал		25.7
ДҮН			202.4

Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчдийн зарцуулах зардлын дээд хэмжээг тухайн тойргоос хамааран 9.7 сая төгрөгөөс 18.6 сая төгрөгийн хооронд тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлсэн нэр дэвшигч байхгүй байна.

2.3 Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-д “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу сонгуулийн зардлын тайлангаа хугацаандаа ирүүлээгүй 58 нэр дэвшигч, намаас ХҮН, САИН, ИХН-ууд байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дүгээр зүйлийн 51.3-д “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй 50 нэр дэвшигч байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Сонгуульд оролцсон зарим нэр дэвшигчид хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас данс бүртгүүлэх, тайлан ирүүлэх зэрэг хуулийн тодорхой заалтуудыг мөрдөөгүй байна.
- Нэр дэвшигч нар тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.
- Нэр дэвшигчдийн 36.8 буюу 306 нь сонгуулийн үйл ажиллагаанд ямар нэгэн зардал гаргаагүй гэж тайлагнасан байна.